



## НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 02 сарын 12 өдөр

Дугаар A/09

Улаанбаатар хот

### Орон тооны бус ёс зүйн албыг шинэчлэн байгуулах тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 30.1.15, 30.2, 30.3, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2013 оны А/811 дүгээр тушаалын 5 дугаар хавсралтаар батлагдсан “Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын албан хаагчийн ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх журмын 2.1, 2.4, 2.5, 2.8-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Онцгой байдлын газрын орон тооны бус ёс зүйн албыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга:

Н.Нямхорлоо

Тэргүүн дэд дарга, дэд хурандаа,

Гишүүд:

Ж.Төмөрмандах

Дотоод, хяналт шинжилгээ, үнэлгээ, эрсдэлийн удирдлагын тасгийн дарга, хошууч,

С.Содонтуяа

Хүний нөөц, бие бүрэлдэхүүний сургалт хариуцсан ахлах мэргэжилтэн, дэд хурандаа,

Ж.Алтанхуяг

Гал түймэр унтраах сургалт хариуцсан ахлах мэргэжилтэн, дэд хурандаа,

Э.Пүрэв-Очир

Хуулийн зөвлөх, өргөдөл гомдол хариуцсан ахлах мэргэжилтэн, энгийн

Нарийн бичиг:

Ч.Батболд

Дотоод, хяналт, шинжилгээ, үнэлгээ ёс зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн, ахмад,

2. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан нийслэлийн Онцгой байдлын газрын даргын 2017 оны А/92 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

3. Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хангуулж бие бүрэлдэхүүний сахилга хариуцлагыг дээшлүүлж хяналт тавьж ажиллахыг ёс зүйн албаны дарга (дэд хурандаа Н.Нямхорлоо)-д үүрэг болгосугай.

ДАРГА,  
ХУРАНДАА



Ж.ЧҮЛТЭМСҮРЭН